



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИХ СУРГУУЛИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/14/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 51-261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Долгоржав
Утас: 51-260512 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бодьтусгал- Аудит ХХК-ийн
Захирал: З.Мягмарсүрэн
Утас: 99080074 Цахим хаяг: boditusgal.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.ДОЛЖИН ТАНАА

2022.03.15 № 07/624
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Gazar-102.Docx

001051050

бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1 626 242 518,13</u>	<u>2 216 313 737,82</u>
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1 397 600 789,73	1 975 401 405,52
	Бангинд байгаа мөнгө	737 461 081,84	1 360 282 024,93
	Богино хугацаат хадгаламж	660 139 707,89	615 119 380,59
	Авлага	51 823 690,00	48 988 800,00
	Төлбөртэй үйлчилгээний авлага	41 823 690,00	48 988 800,00
	Бусад авлага	10 000 000,00	
35	БАРАА МАТЕРИАЛ	176 818 038,40	191 923 532,30
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	176 818 038,40	191 923 532,30
35420	Аж ахуйн материал	176 818 038,40	191 923 532,30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8 599 569 843,46</u>	<u>8 391 175 327,30</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8 599 569 843,46	8 391 175 327,30
392	Биет хөрөнгө	6 197 189 247,67	6 001 567 433,15
39201	Барилга, байгууламж, орон сууц	6 183 999 716,59	6 274 300 428,59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(542 157 903,59)	(800 733 209,00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18 149 750,00	18 149 750,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(6 049 311,72)
39205	Машин тоног төхөөрөмж	450 966 721,42	435 045 834,52
39206	Хуримтлагдсан элэгдэл	(218 348 135,95)	(241 342 485,96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	389 215 683,21	421 491 520,96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(217 790 084,01)	(232 448 594,24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	133 153 500,00	133 153 500,00
393	Биет бус хөрөнгө	2 402 380 595,79	2 389 607 894,15
39301	Програм хангамж	12 762 180,00	12 762 180,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5 282 812,21)	(6 957 030,09)
39303	Бусад биет бус хөрөнгө	2 049 675 000,00	2 049 675 000,00
	Номын фонд	292 815 438,35	298 572 228,35
	Нийтийн тохижилтын хөрөнгө	65 169 229,00	65 169 229,00
	Хуримтлагдсан элэгдэл	(21 899 818,50)	(35 419 290,74)
	Бусад үндсэн хөрөнгө	12 470 032,90	12 470 032,90
	Хуримтлагдсан элэгдэл	(3 328 653,75)	(6 664 455,27)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10 225 812 361,59</u>	<u>10 607 489 065,12</u>

	Өр төлбөр	383 192 833,00	368 731 552,00
	Бараа үйлчилгээний зардлын тооцоо	10 000 000,00	
	УОО	373 192 833,00	368 731 552,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9 842 619 528,59	10 238 757 513,12
51	Засгийн газрын хувь оролцоо	9 842 619 528,59	10 238 757 513,12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5 640 076 523,69	5 640 076 523,69
512	Хуримтлагдсан үр дүн	1 101 593 336,13	1 497 731 320,66
51210	Өмнөх үеийн үр дүн	1 101 593 336,13	1 101 593 336,13
51220	Тайлант үеийн үр дүн		396 137 984,53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3 100 949 668,77	3 100 949 668,77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10 225 812 361,59	10 607 489 065,12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3 077 346 358,84	2 902 548 482,74
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2 712 396 299,12	2 772 080 790,59
120	Нийтлэг татварын бус орлого	2 712 396 299,12	2 772 080 790,59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1 865 282 093,00	2 052 130 125,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	829 230 213,12	688 257 559,14
1200045	Торгууль төлбөрийн орлого	17 883 993,00	31 693 106,45
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	364 950 059,72	130 467 692,15
1310	Улсын төсвөөс	206 583 547,00	107 425 260,00
131001	Хөрөнгийн	35 000 000,00	
	Орон нутгийн төсвөөс	55 150 360,00	98 677 760,00
	Бусад төсөвт байгууллагаас	116 433 187,00	8 747 500,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158 366 512,72	23 042 432,15
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	158 366 512,72	23 042 432,15
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2 647 098 109,81	2 506 410 498,21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 647 098 109,81	2 506 410 498,21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 605 122 009,81	2 481 173 412,21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 573 272 481,27	1 479 338 713,02
210101	Үндсэн цалин	1 573 272 481,27	1 479 338 713,02

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201 857 908,01	194 269 202,91
210201	Тэтгэврийн даатгал	201 857 908,01	194 269 202,91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220 701 801,45	113 655 950,34
210301	Гэрэл, цахилгаан	76 673 598,28	31 070 787,49
210302	Түлш, халаалт	102 255 864,39	56 557 637,12
210303	Цэвэр, бохир ус	41 772 338,78	26 027 525,73
2104	Хангамж, бараа материалын зардал	123 504 663,55	160 825 169,46
210401	Бичиг хэрэг	1 723 898,17	1 739 083,07
210402	Тээвэр, шатахуун	1 086 710,00	1 633 668,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13 695 922,62	7 908 189,96
210405	Хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардал	69 936 626,76	86 245 600,86
210408	Сургалт семинарын зардал	24 978 986,00	19 746 224,00
	Эрдэм шинжилгээний ажлын зардал	12 082 520,00	43 552 403,57
2105	Нормативт зардал	-	89 100,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		89 100,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60 443 022,84	75 633 840,40
210603	Жижиг эд хогшил худалдан авах зардал	13 767 387,00	9 343 555,91
210604	Урсгал засвар	46 675 635,84	66 290 284,49
2107	Томилолт, зочны зардал	2 375 800,00	1 169 200,00
210702	Дотоод албан томилолт	2 375 800,00	1 169 200,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52 341 503,08	39 571 139,92
210803	Харуул хамгаалалт	35 626 500,00	21 060 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	65 000,00	465 000,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	16 650 003,08	17 206 139,92
210809	Түрээс		840 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	370 624 829,61	416 621 096,16
210901	Оюутны үйл ажиллагааны зардал	17 029 275,00	7 192 971,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	353 595 554,61	409 407 035,16
	Хөрөнгө худалдсаны гарз		21 090,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41 976 100,00	25 237 086,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	41 976 100,00	25 237 086,00
213204	Хөтөлбөр арга хэмжээний зардал	7 185 000,00	5 117 886,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34 791 100,00	20 119 200,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	430 248 249,03	396 137 984,53
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	430 248 249,03	396 137 984,53

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,640,076,523.69	3,100,949,668.77	671,345,087.10	9,412,371,279.56
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	74,573,916.00		74,573,916.00
C07	Тайлант үеийн үр дүн			355,674,333.03	355,674,333.03
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,640,076,523.69	3,250,097,500.77	1,382,693,753.16	9,842,619,528.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(74,573,916.00)		(74,573,916.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-		74,573,916.00	74,573,916.00
D08	Тайлант үеийн үр дүн			396,137,984.53	396,137,984.53
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,640,076,523.69	3,100,949,668.77	1,497,731,320.66	10,238,757,513.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2 700 718 950,53	2 864 430 664,92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2 700 718 950,53	2 864 430 664,92
1310	Улсын төсвөөс	35 000 000,00	-
131001	Хөрөнгийн	35 000 000,00	-
	Орон нутгийн төсвөөс	55 150 360,00	98 677 760,00
	Бусад төсөв байгууллагаас	30 974 400,00	197 356 240,00
1311	Төсөвт байгууллагын төлбөртэй үйлчилгээ	2 579 594 190,53	2 568 396 664,92
131101	Сургалтын төлбөрийн орлого	1 844 329 260,00	1 833 458 154,00
131103	Оюутны байрны орлого	228 096 750,00	151 848 630,00
131104	Үйл ажиллагааны бус орлого	507 168 180,53	583 089 880,92
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2 210 892 844,18	2 196 329 337,13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 210 892 844,18	2 196 329 337,13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 176 067 994,18	2 175 881 137,13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 563 341 295,58	1 483 595 833,34
210101	Үндсэн цалин	1 563 341 295,58	1 483 595 833,34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118 723 923,54	168 622 306,17
210201	Тэтгэврийн даатгал	118 723 923,54	168 622 306,17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133 211 091,36	112 995 764,14
210301	Гэрэл, цахилгаан	41 679 962,00	31 249 522,49
210302	Түлш, халаалт	68 124 905,36	55 718 715,92
210303	Цэвэр, бохир ус	23 406 224,00	26 027 525,73
2104	Хангамж, бараа материалын зардал	6 042 372,62	6 326 997,96
210401	Бичиг хэрэг	1 681 660,00	2 035 260,00
210402	Тээвэр, шатахуун	1 531 790,00	1 722 768,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 828 922,62	2 568 969,96
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	144 917 147,00	182 601 239,00
210601	Аж ахуйн зардал	17 245 387,00	18 264 569,00
210604	Урсгал засвар	49 631 720,00	63 757 273,00
	Тоног төхөөрөмж худладан авах зардал	50 671 300,00	32 372 607,00
	Тавилга эдхогшил худалдан авах зардал	14 497 500,00	62 450 000,00
	Ном сурах бичиг худалдан авах зардал	6 429 060,00	5 756 790,00
	Биет бус хөрөнгө	6 442 180,00	-

2107	Томилолт, зочны зардал	2 231 800,00	840 200,00
210702	Дотоод албан томилолт	2 231 800,00	840 200,00
2108	Сургалтын үйл ажиллагааны зардал	95 760 827,08	98 367 538,52
210801	Багш ажилтны үйл ажиллагааг дэмжих зардал	24 889 986,00	17 173 399,00
210802	Мэргэжлийн олимпиадын зардал	141 000,00	275 000,00
210803	Оюутны үйл ажиллагаа дэмжих зардал	15 958 940,00	6 374 474,60
210804	Оюутны тэтгэлэг		210 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10 867 000,00	5 280 000,00
210807	Хэвлэл мэдээлэл сурталчилгааны зардал	65 000,00	465 000,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	18 452 381,08	23 643 889,92
210809	Эрдэм шинжилгээ инновацийн зардал	323 200,00	27 750 500,00
	Судалгааны суурь зардал	11 099 320,00	
	Өндөр түвшин судалгаа залуу судлаач		10 355 275,00
	Эрдэм шинжилгээний зардал /гэрээт ажил төсөл хөтөлбөр/	13 964 000,00	6 840 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111 839 537,00	122 531 258,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	69 028 037,00	96 353 372,00
	Харуул хамгаалалтын зардал	35 626 500,00	21 060 000,00
	Төвлөрсөн арга хэмжээний зардал	7 185 000,00	5 117 886,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34 824 850,00	20 448 200,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	34 824 850,00	20 448 200,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2 645 000,00	1 664 000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27 821 100,00	10 280 400,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4 358 750,00	8 503 800,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>489 826 106,35</u>	<u>668 101 327,79</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27 993 729,00	90 300 712,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27 993 729,00	90 300 712,00
2200	Дотоод эх үүсвэрээр	27 993 729,00	90 300 712,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>461 832 377,35</u>	<u>577 800 615,79</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,793,747,700.00	2,286,630,049.13	(1,507,117,650.87)	60.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,793,747,700.00	2,286,630,049.13	(1,507,117,650.87)	60.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,731,667,800.00	2,269,896,763.13	(1,461,771,036.87)	60.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,012,438,600.00	1,481,585,833.34	(530,852,766.66)	73.6
210101	Үндсэн цалин	2,012,438,600.00	1,481,585,833.34	(530,852,766.66)	73.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	271,679,200.00	168,394,456.17	(103,284,743.83)	62.0
210201	Тэтгэврийн даатгал	271,679,200.00	168,394,456.17	(103,284,743.83)	62.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,108,400.00	112,995,764.14	(47,112,635.86)	70.6
210301	Гэрэл, цахилгаан	53,962,200.00	31,249,522.49	(22,712,677.51)	57.9
210302	Түлш, халаалт	74,952,000.00	55,718,715.92	(19,233,284.08)	74.3
210303	Цэвэр, бохир ус	31,194,200.00	26,027,525.73	(5,166,674.27)	83.4
2104	Хангамж, бараа материалын зардал	81,503,200.00	29,871,566.96	(51,631,633.04)	36.7
210401	Бичиг хэрэг	5,554,600.00	2,035,260.00	(3,519,340.00)	36.6
210402	Тээвэр, шатахуун	7,804,800.00	1,722,768.00	(6,082,032.00)	22.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,580,000.00	7,848,969.96	(11,731,030.04)	40.1
210405	Аж ахуйн зардал	47,363,800.00	18,264,569.00	(29,099,231.00)	38.6
	Тогтмол хэвлэлийн зардал	1,200,000.00	-	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,576,900.00	63,757,273.00	(39,819,627.00)	61.6
210604	Урсгал засвар	103,576,900.00	63,757,273.00	(39,819,627.00)	61.6
2107	Томилолт, зочны зардал	49,906,500.00	1,169,200.00	(48,737,300.00)	2.3
	Гадаад арга хэмжээ хамтын ажиллагааны зардал	41,280,000.00	-	-	
210702	Дотоод албан томилолт	8,626,500.00	1,169,200.00	(7,457,300.00)	13.6
2108	Сургалтын үйлчилгээний зардал	452,431,600.00	200,182,560.52	(252,249,039.48)	44.2
210801	Багшийн дэмжих үйл ажиллагааны зардал	55,473,100.00	17,173,399.00	(38,299,701.00)	31.0
	ЭШ-ийн инновацийн зардал	115,230,000.00	47,183,625.00	(68,046,375.00)	40.9
210802	Мэргэжлийн олимпиадын зардал	4,345,000.00	275,000.00	(4,070,000.00)	6.3
210803	Тусламж тэтгэлэгийн зардал	8,300,000.00	8,503,800.00	203,800.00	102.5

210804	Уралдаан тэмцээний зардал	2,040,000.00		(2,040,000.00)	0.0
210805	Оюутны үйлчилгээний зардал	28,147,000.00	6,374,474.60	(21,772,525.40)	22.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,700,000.00	465,000.00	(8,235,000.00)	5.3
210807	Оюутны тэтгэлэг	6,500,000.00	210,000.00	(6,290,000.00)	3.2
	Түрээсийн төлбөр	1,540,000.00	4,621,850.00		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	59,773,500.00	19,022,039.92	(40,751,460.08)	31.8
210809	Хичээл практикийн зардал	162,383,000.00	96,353,372.00	(66,029,628.00)	59.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600,023,400.00	211,940,109.00	(388,083,291.00)	35.3
	Харуул хамгаалалтын зардал	42,120,000.00	21,060,000.00	(21,060,000.00)	50.0
	Барилга байгууламж их засварын зардал	233,819,100.00	90,300,712.00	(143,518,388.00)	38.6
	СТТ худалдан авах зардал	183,775,700.00	32,372,607.00	(151,403,093.00)	17.6
	Тавилга эд хогшил худалдан авах зардал	117,508,600.00	62,450,000.00	(55,058,600.00)	53.1
	Ном сурах бчгийн зардал	22,000,000.00	5,756,790.00	(16,243,210.00)	26.2
	Биет бус хөрөнгө	800,000.00		(800,000.00)	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,079,900.00	16,733,286.00	(45,346,614.00)	27.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,079,900.00	16,733,286.00	(45,346,614.00)	27.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,279,900.00	10,280,400.00	(17,999,500.00)	36.4
	Төвлөрсөн арга хэмжээ	27,500,000.00	5,117,886.00	-	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,300,000.00	1,335,000.00	(4,965,000.00)	21.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,667,131,100.00	2,864,430,664.92	197,299,564.92	107.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	84,045,000.00	98,677,760.00	14,632,760.00	117.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	84,045,000.00	98,677,760.00	14,632,760.00	117.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,583,086,100.00	2,765,752,904.92	182,666,804.92	107.1
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,762,856,500.00	2,034,536,594.00	-	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	820,229,600.00	731,216,310.92	(89,013,289.08)	89.1

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтын талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 15-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Бодьтусгал-Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юмчмаа, аудитор С.Батгэрэл нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал З.Мягмарсүрэн хэрэгжүүлсэн.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь эдийн засаг, худалдаа, үйлдвэрлэл, бизнесийн чиглэлээр иргэдэд боловсрол эзэмшүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажил эрхлэн шинэ мэдлэг бүтээх, хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх, бүх талын үйлчилгээ үзүүлэх, Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

- Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон.
- Дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.
- Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Засгийн газрын 2021 оны 102 дугаар тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, мөн Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор “Босго үнэ шинэчлэн батлах” тухай шийдвэрүүд тус тус шинэчлэгдэн гарсан байна.
- Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.
- Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр АХГ-2022/14/НА-СТА-ТӨА

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,647.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 26.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж материаллаг байдлын суурь үзүүлэлт болох нийт зардал өмнөх оноос өссөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,506.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 190.9 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө хөрөнгө	1,397,600.8	1,975,401.4	577,800.62
Бангинд байгаа мөнгө	737,461.1	1,360,282.0	622,820.94
Богино хугацаат хадгаламж	660,139.7	615,119.4	(45,020.33)
Авлага	51,823.7	48,988.8	(2,834.89)
Төлбөртэй үйлчилгээний авлага	41,823.7	48,988.8	7,165.11
Бусад авлага	10,000.0	-	(10,000.00)
БАРАА МАТЕРИАЛ	176,818.0	191,923.5	15,105.49
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,599,569.8	8,391,175.3	(208,394.52)
Биет хөрөнгө	6,197,189.2	6,001,567.4	(195,621.81)
Биет бус хөрөнгө	2,402,380.6	2,389,607.9	(12,772.70)
Програм хангамж	7,479.4	12,762.2	5,282.81
Бусад биет бус хөрөнгө	2,049,675.0	2,049,675.0	-
Номын фонд	292,815.4	298,572.2	5,756.79
Нийтийн тохижилтын хөрөнгө	43,269.4	65,169.2	21,899.80
Бусад үндсэн хөрөнгө	9,141.4	12,470.0	3,328.65
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,225,812.4	10,607,489.1	381,676.70
Өр төлбөрийн дүн	383,192.8	368,731.6	(14,461.28)
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	10,000.0	-	(10,000.00)
УОО	373,192.8	368,731.6	(4,461.28)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,842,619.5	10,238,757.5	396,137.98

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,640,076.5	5,640,076.5	-
Хуримтлагдсан үр дүн	1,101,593.3	1,497,731.3	396,137.98
Өмнөх үеийн үр дүн	1,101,593.3	1,101,593.3	-
Тайлант үеийн үр дүн	-	396,138.0	396,137.98
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,100,949.7	3,100,949.7	-
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,225,812.4	10,607,489.1	381,676.70

Дансны үлдэгдэлд дараах материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 191.9 сая төгрөг болж өмнөх оноос 15.1 сая төгрөгөөр өссөн нь хичээл практиктай холбоотой бичгийн цаас, принтер, каноны хор зэргийн худалдан авалтаас шалтгаалсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,720.7 сая төгрөг болж урд оноос 190.9 сая төгрөгөөр өссөн нь тайланд онд 32.4 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, 62.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, барилгын засварт 90.3 сая төгрөгийн материал зэргийг худалдан авсан, хандиваар 18.9 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үйл ажиллагааны орлого	3 077 346,3	2 902 548,5	(174 797,8)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2 712 396,3	2 772 080,8	59 684,5
Тусламж санхүүжилтийн орлого	364 950,0	130 467,7	(234 482,3)
Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	1 573 272,5	1 479 338,7	(93 933,8)
Нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201 857,9	194 269,2	(7 588,7)
Бараа үйлчилгээний бусад зардал	871 967,7	832 781,5	(39 186,2)
Үйл ажиллагааны зардал	1 775 130,4	1 673 607,9	(101 522,5)
Үйл ажиллагааны бус зардал		21,1	21,1
Үр дүн	430 248,2	396 138,0	(34 110,2)

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 174.8 сая төгрөг буюу 5.7 хувиар буурсан нь тусламж санхүүжилтийн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 140.7 сая төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан байна. Зардлыг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад цалин, гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардлууд буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,847.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 3,793.7 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалыг 557.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, удирдах зөвлөлд хүргүүлсэн.

Тус сургуулийн удирдах зөвлөл төсвийн дагуу нийт зардлыг 3,793.7 сая төгрөгт багтаан зарцуулахаар, ажиллагсдын тоог 117 орон тоотой байхаар баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 2,133.2 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 578.7 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 152.5 сая төгрөг нийт 2,864.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл батлагдсан төсвөөс 1,507.1 сая төгрөг буюу 60.3 хувиар хэмнэгдсэн байна. Тухайлбал цалин хөлсний зардал 634.1 сая төгрөг, бараа үйлчилгээний нийтлэг зардал 220.9 сая төгрөг, сургалтын үйлчилгээний зардал 148.8 сая төгрөг, эрдэм шинжилгээ иновацийн зардал 68.1 сая төгрөг, тогтмол зардал 68.2 сая төгрөг, хөрөнгийн зардал 367.0 сая төгрөгийн зардлууд буурсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь нийт 80 гаруй эрдэмтэн багш, үйлчилгээний ажилтнуудыг түшиглэн худалдаа, санхүү нягтлан бодох бүртгэл, маркетинг, эрх зүйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэхэд үндсэн гол үйл ажиллагаа нь чиглэгдэж байна.

Тайлант онд тус сургууль нь үндсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр зорилт тавьж, ажилласан байна. Үүнд:

1. Засгийн газрын болон бусад бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний хүрээнд 23 ажил,
2. Өөрийн стратеги төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хүрээ (сургалтын шинэчлэл, эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэх, нийгэмд нөлөө бүхий жишиг байгууллага болох) - нд 44 ажил хийхээр төлөвлөж, нийт гүйцэтгэл нь 98.0 хувьтай байна.

3.8 Аудитын гол асуудал

Удирдах зөвлөлөөс баталсан төсвийн орлогын зарцуулалтын талаарх шийдвэрийг үндэслэн зарцуулалтыг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа нь хууль дүрэм журамд заасантай бүрэн нийцэхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль нь 2021 онд 5.0 сая төгрөгөөс дээш нийт 1,922.5 сая төгрөгийн 279 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,922.5 сая төгрөгийн 279 мэдээллийг байршуулсан ба зөрчил гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 84.5 сая төгрөгийн 5 алдаа зөрчилд зөвлөмж өгч зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад сургалтын төлбөрийн тооцоо, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдэл, томилолтын зардалтай холбоотой 84.5 сая төгрөгийн 5 зөвлөмжийг биелүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд 11 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн албан шаардлагын биелэлт 100 хувь, Хөвсгөлийн усан зам ХК-ийн нийт хувьцааны 25 хувь болох нэг бүр нь 12 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 23,606 ширхэг хувьцааг 100.0 сая төгрөгийн авлагад суутган авч, эргэлтийн бус хөрөнгийн бусад хэсэгт бүртгэснийг ТӨБЗГазраар шийдвэрлүүлэх албан шаардлагын биелэлт 80 хувь, 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	100,000.0	2	100,000.0	-	-	90.0
Зөвлөмж	1	23,600.0	1	23,600.0	-	-	100.0
Нийт дүн	3	123,600.0	3	123,600.0		-	95.0

Бараа ажил үйлчилгээ худалдан авалттай холбоотой захирлын тушаал шийдвэрийн талаар өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн сургалтын төлбөрийн тооцоо, бараа ажил үйлчилгээний худалдан авалт, батлагдсан төсвийн зарцуулалт, захирлын тушаал шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 109.3 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 84.5 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 3.9 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 95.5 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1. Зардлын данстай холбоотой асуудал

1.Илрүүлэлт :

Боловсролын байгууллагын 100 жилийн ойд 2.6 сая төгрөг, Худалдааны байгууллагын 100 жилийн арга хэмжээнд 0.9 сая төгрөг, Шинжлэх ухааны академийн 100 жилд 0.4 сая төгрөг нийт 3.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3-д “..... зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г,м)-ын зардлыг гаргахгүйбайх”, 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр, ёслол, тэмдэглэлт ой, спортын уралдаан тэмцээн зохион

байгуулахгүй байх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй зэрэг нь нийцсэн байх, үнэн зөв байх зэрэг батламж мэдэгдэлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урьдчилж орсон орлогын данс, дотоод хяналттай холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Урьдчилж орсон орлого дансанд урьдчилж төлбөрөө төлсөн 8 оюутны 10.6 сая төгрөг, 2022 оны 1 дүгээр сарын зардлыг нөхөх 186.7 сая төгрөгийг тусад нь салгалгүй, нэг дансанд бүртгэсэн, сургалтын төлбөрийн тооцоонд тавих дотоод хяналт хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх, үнэлгээ хуваарилалт, ангилал, иж бүрэн байх, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдэлүүдийг хангаагүй байна.

2. Өгсөн зөвлөмж:

Оюутны илүү шилжүүлсэн болон дараа оны 1 дүгээр сарын зардал нөхөх дүнг бакалавр, магистр тус бүрээр салгаж бүртгэх, сургалтын төлбөрийн тооцоонд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

2. Удирдах зөвлөлийн баталсан төсөвтэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт

Удирдах зөвлөлийн баталсан төсвийг хэтрүүлээгүй боловч зарим зардлын зүйл ангийг зөрүүлэн нийт 20.9 сая төгрөгийг бүртгэсэн байна. Үүнд:

- Төлбөр хураамжийн зардалд 1.9 сая төгрөгийн захирлын уулзалт, хурал зөвлөгөөнд оролцсон зардлыг
- Хичээл практикийн зардалд 3.9 сая төгрөгийн Худалдааны болон Боловсролын байгууллагын ойн арга хэмжээний зардлыг
- Оюутны үйл ажиллагааны зардалд 5.1 сая төгрөгийн уралдаан тэмцээний зардлыг
- Эрдэм шинжилгээ иновацийн зардалд 10.0 сая төгрөгийн Худалдааны байгууллагын 100 жилийн ойд зориулан гаргасан номын хэвлэлтийн зардлыг тус тус зөрүүлж бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх” /,16.5.5. "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх, үнэлгээ хуваарилалт, иж бүрэн байх, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдэлүүдийг хангаагүй байна.

2.Өгсөн зөвлөмж

Төсвийг хууль дүрэм журамд нийцүүлэн, үндэслэлтэй боловсруулах, Удирдах зөвлөлийн баталсан зардлын ангиллаар бүртгэлийг хөтөлж, тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/												
д/ д	Байгуул- лагын нэр	Аудит ын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс					
							Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар												
1	ХҮИС	АХГ- 2022 /14/Н А- СТА- ТӨА	Санхүүгийн тайлангийн дахин үнэлгээний нэмэгдлийн эхний үлдэгдэл тайлант онд 3,100.9 сая төгрөг, өмнөх оны аудит хийсэн тайлангийн эцсийн үлдэгдэл 3,175.5 сая төгрөг, зөрүү өмнөх оны аудит хийгдсэнээс хойш БШУЯ 2020 оны санхүүгийн тайланд дахин үнэлгээний 74.6 сая төгрөгийг хуримтлагдсан ашиг руу хаасантай холбоотой байна.	Цаашид аудитын тайлан батлагдасны дараа залруулга хийхгүй байх, зайлшгүй хийх тохиолдолд аудитын тайланд засвар хийх талаар албан бичгээр мэдэгдэх	1	74,573.9	1	74,573.9				
2	ХҮИС	АХГ- 2022 /14/Н А- СТА- ТӨА	Урьдчилж орсон орлого дансанд урьдчилж төлбөрөө төлсөн 8 оюутны 10.6 сая төгрөг, 2022 оны 1 дүгээр сарын зардлыг нөхөх 186.7 сая төгрөгийг тусад нь салгалгүй, нэг дансанд нэгтгэн бүртгэсэн, сургалтын төлбөрийн тооцоонд тавих дотоод хяналт хангалтгүй	Оюутан кредитээ үзээгүй байхдаа шилжүүлсэн мөнгөн дүн, дараа оны 1 дүгээр сарын зардал нөхөх дүнг бакалавр, магистер тус бүрийн дансыг салгаж бүртгэх, оюутны төлбөрийн тооцоог нарийвчлан шалгаж, төлбөрөө дутуу төлсөн оюутны тооцоог авлагаар бүртгэх эсэх талаар шийдвэрлэж, баримтжуулах	1	-	-			1	-	

3	ХҮИС	АХГ-2022 /14/Н А-СТА-ТӨА	Удирдах зөвлөлийн баталсан төсвийг хэтрүүлээгүй боловч зарим зардлын зүйл ангийг зөрүүлэн бүртгэсэн байна. Үүнд: Төлбөр хураамжийн зардалд 1.9 сая төгрөгийн захирлын уулзалт, хурал зөвлөгөөнд оролцсон зардлыг, хичээл практикийн зардалд 3.9 сая төгрөгийн Худалдааны болон Боловсролын байгууллагын ойн арга хэмжээний зардлыг, оюутны үйл ажиллагааны зардалд 5.1 сая төгрөгийн уралдаан тэмцээний зардлыг, эрдэм шинжилгээ иновацийн зардалд 10.0 сая төгрөгийн Худалдааны байгууллагын 100 жилийн ойд зориулан гаргасан номын хэвлэлтийн зардлыг оруулан нийт 20.9 сая төгрөгийг бүртгэсэн байна.	Батлагдсан төсвийн гүйцэтгэлд эдийн засгийн шинжилгээ хийж түүний үндсэн дээр бодитоор төлөвлөх, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн зарцуулалтыг хийх.	1	20,888.8	-	-	1	20,888.8		
4	ХҮИС	АХГ-2022 /14/Н А-СТА-ТӨА	Боловсролын байгууллагын 100 жилийн ойд 2.6 сая төгрөг, Худалдааны байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээнд 0.9 сая төгрөг, ШУА-ийн 100 жилд 0.4 сая төгрөг, нийт 3.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.	Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж,төсөвт зардлыг хэмнэхэд чиглэн гаргасан арга хэмжээ, хууль, дүрэм, журамд нийцүүлэн ажиллах	1	3,866.9		1	3,866.9			
5	ХҮИС	АХГ-2022/ 14/ НА-СТА-ТӨА	Завсарын аудитаар илэрсэн 5 алдаа зөрчилд зөвлөмж өгсөнийг жилийн эцсийн аудитаар хянахад 4 алдаа залруулж 9.9 сая төгрөгийн зөрчлийг арилгасан байна	Анхан шатны баримтыг бүрдүүлэх , сургалтын төлбөрийн тооцоог дахин хянах	4	9,930.0	4	9,930.0				
Нийт дүн					8	109,259.6	5	84,503.9	1	3,866.9	2	20,888.8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 572/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/14/НА - СТА-ТОА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Боловсролын байгууллагын 100 жилийн ойд 2,571,430.00 төгрөг, Худалдааны байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээнд 875,526.00 төгрөг, ШУА-ийн 100 жилд 419,900.00 төгрөг нийт 3,866,856.00 төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3 "...зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр, ёслол, тэмдэглэлт ой, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн захирал М.Должин, Ерөнхий нягтлан бодогч Л.Гоёцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ

БОДЬТУСГАЛ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

З.МЯГМАРСҮРЭН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-249.Docx

0001081479